



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төвшрүүлэх сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/94/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2022 он</p>	<p>Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас:7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК Утас: 99099119 Цахим хаяг: gerelthuhaudit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	111
3. Аудитын тайлан.....	122
3.1 Ерөнхий зүйл.....	122
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	122
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа	16
4.2 Албан шаардлага	16
5. Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл.....	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

ТӨВШРҮҮЛЭХ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
А.РЭНЦЭНХАНД ТАНАА

2022.02.22 № 41
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төвшрүүлэх сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төвшрүүлэх сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг..

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *T. Baygalmaa* Т. БАЙГАЛМАА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөг /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	88,396,722.79	98,750,990.82
33	АВЛАГА	2,113,347.89	
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,113,347.89	
35	БАРАА МАТЕРИАЛ	86,283,374.90	98,750,990.82
351	Түүхий эд материал	491,800.00	4,424,400.00
3513	Эм боох материал	491,800.00	4,424,400.00
354	Хангамжийн материал	85,791,574.90	94,326,590.82
3541	Бичиг хэргийн материал	3,509,803.84	3,814,203.84
3542	Аж ахуйн материал	79,668,645.46	87,574,371.38
3544	Түлш, шатах тослох материал	1,348,729.20	1,348,729.20
3545	Барилгын засварын материал	1,024,396.40	1,328,036.40
3546	Хүнсний материал		21,250.00
3547	Бусад хангамжийн материал	240,000.00	240,000.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,394,338,824.60	3,300,326,634.85
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,394,338,824.60	3,300,326,634.85
392	Биет хөрөнгө	3,314,137,157.87	3,220,344,968.08
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,323,496,109.43	3,323,496,109.43
39202	Хуримтлагдсан элэгдэл	-238,131,163.55	-318,696,788.39
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,000,000.00	14,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-14,000,000.00	-14,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	286,172,729.14	257,875,879.11
39206	Хуримтлагдсан элэгдэл	-167,105,372.82	-132,234,295.98
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	173,933,405.53	169,866,772.03
39208	Хуримтлагдсан элэгдэл	-85,454,645.78	-99,954,612.68
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,860,500.00	8,280,638.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,422,816.83	-5,077,146.19
39217	Ном	16,788,412.75	16,788,412.75
393	Биет бус хөрөнгө	80,201,666.73	79,981,666.77
39301	Програм хангамж	2,072,000.00	2,072,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-780,333.27	-1,000,333.23
39303	Бусад биет бус хөрөнгө	78,910,000.00	78,910,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,482,735,547.39	3,399,077,625.67
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,482,735,547.39	3,399,077,625.67
51	Засгийн газрын хувь оролцоо	3,482,735,547.39	3,399,077,625.67
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	668,891,192.58	668,891,192.58
51101	Өмч: - төрийн		
512	Хуримтлагдсан үр дүн	2,307,117,005.24	2,223,459,083.52
5121	Өмнөх үеийн үр дүн	2,307,117,005.24	2,307,117,005.24
5122	Тайлант үеийн үр дүн		-83,657,921.72
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	506,727,349.57	506,727,349.57
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,482,735,547.39	3,399,077,625.67

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,083,630,916.69	1,009,504,598.77
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	104,973,316.69	36,739,715.13
120	Нийтлэг татварын бус орлого	104,973,316.69	36,739,715.13
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	104,973,316.69	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		32,997,739.21
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		3,741,975.92
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	978,657,600.00	972,764,883.64
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	901,732,000.00	917,815,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	901,732,000.00	917,815,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	400,000.00	1,293,883.64
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	400,000.00	1,293,883.64
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	76,525,600.00	53,655,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	76,525,600.00	53,655,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,040,577,135.26	1,093,162,520.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,040,577,135.26	1,093,162,520.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,027,367,455.26	1,034,682,958.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	708,687,981.00	708,079,268.00
210101	Үндсэн цалин	504,247,900.00	507,467,242.00
210102	Нэмэгдэл	137,972,300.00	138,593,225.00
210104	Урамшуулал	66,467,781.00	62,018,801.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,374,436.71	91,954,116.66
210201	Тэтгэврийн даатгал	58,965,972.61	63,354,513.10
210202	Тэтгэмжийн даатгал	7,113,771.74	7,333,673.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,685,892.16	5,890,913.16
210204	Ажилгүйдлийн даатгал	1,381,251.72	1,408,405.67
210205	Эрүүл мэндийн даатгал	14,227,548.48	13,966,610.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,534,600.00	48,097,600.00
210301	Гэрэл, цахилгаан	12,815,340.46	13,096,068.12
210302	Түлш, халаалт	57,719,259.54	35,001,531.88
2104	Хангамж, бараа материалын зардал	11,077,425.00	5,091,983.64
210401	Бичиг хэрэг	461,730.00	726,883.64
210402	Тээвэр, шатахуун	3,563,795.00	2,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,821,100.00	729,600.00
210404	Ном, хэвлэл	163,000.00	105,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	265,100.00	501,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	505,800.00	1,029,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	25,900.00	
210408	Бараа материал акталсны зардал	4,271,000.00	
2105	Нормативт зардал	30,832,796.00	38,911,001.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,108,500.00	6,171,250.00
210502	Хоол, хүнс	27,196,296.00	32,739,751.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,528,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,014,230.00	6,888,860.00
210604	Урсгал засвар	1,014,230.00	6,888,860.00
2107	Томилолт, зочны зардал	331,400.00	82,200.00

Төвшрүүлэх сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	331,400.00	82,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,053,900.00	6,345,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,528,900.00	5,545,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	525,000.00	800,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	115,460,686.55	129,232,828.96
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,064,750.00	2,222,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	112,395,936.55	127,009,928.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,209,680.00	58,479,562.23
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,209,680.00	16,526,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,941,680.00	14,976,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,268,000.00	1,550,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		41,952,662.23
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		41,952,662.23
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
	Дотоод эх үүсвэрээр		
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	43,053,781.43	-83,657,921.72
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		
V	НИИТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	43,053,781.43	-83,657,921.72

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөг/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	668,891,192.58	506,727,349.57	2,307,117,005.24	3,482,735,547.39
2	Тайлант үеийн үр дүн			-83,657,921.72	-83,657,921.72
3	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	668,891,192.58	506,727,349.57	2,223,459,083.52	3,399,077,625.67

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөг/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	978,657,600.00	972,764,883.64
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	978,657,600.00	972,764,883.64
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	901,732,000.00	917,815,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	901,732,000.00	917,815,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	400,000.00	1,293,883.64
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	400,000.00	1,293,883.64
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	76,525,600.00	53,655,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	76,525,600.00	53,655,600.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	948,795,390.00	972,764,883.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	948,795,390.00	972,764,883.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	922,770,468.99	914,264,071.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	708,687,981.00	708,079,268.00
210101	Үндсэн цалин	504,247,900.00	507,467,242.00
210102	Нэмэгдэл	137,972,300.00	138,593,225.00
210104	Урамшуулал	66,467,781.00	62,018,801.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	89,393,711.99	89,840,768.77
210201	Тэтгэврийн даатгал	60,985,247.89	61,241,165.21
210202	Тэтгэмжийн даатгал	7,113,771.74	7,333,673.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,685,892.16	5,890,913.16
210204	Ажилгүйдлийн даатгал	1,381,251.72	1,408,405.67
210205	Эрүүл мэндийн даатгал	14,227,548.48	13,966,610.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,700,600.00	48,325,600.00
210301	Гэрэл, цахилгаан	12,815,340.46	13,096,068.12
210302	Түлш, халаалт	57,885,259.54	35,229,531.88
2104	Хангамж, бараа материалын зардал	8,840,895.00	5,959,883.64
210401	Бичиг хэрэг	1,297,800.00	1,058,883.64
210402	Тээвэр, шатахуун	3,563,795.00	2,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,821,100.00	729,600.00
210404	Ном, хэвлэл	381,400.00	265,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	265,100.00	858,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,511,700.00	1,047,300.00
2105	Нормативт зардал	36,328,091.00	46,205,051.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,392,300.00	10,986,400.00
210502	Хоол, хүнс	26,279,491.00	32,739,751.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,656,300.00	2,478,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,539,250.00	5,300,000.00
210604	Урсгал засвар	1,539,250.00	5,300,000.00
2107	Томилолт, зочны зардал	331,400.00	82,200.00
210702	Дотоод албан томилолт	331,400.00	82,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,288,000.00	7,830,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,763,000.00	7,030,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	525,000.00	800,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,660,540.00	2,640,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,660,540.00	2,640,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,024,921.01	58,500,812.23
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,207,480.00	16,548,150.00

Төвшрүүлэх сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,939,480.00	14,998,150.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,268,000.00	1,550,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,817,441.01	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,817,441.01	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		41,952,662.23
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		41,952,662.23
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	29,862,210.00	
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	29,862,210.00	
22	Биет ба биет бус хөрөнгө худалдан авах Дотоод эх үүсвэрээр	29,862,210.00	
221001	Их засвар	6,245,750.00	
222001	Тоног төхөөрөмж	23,466,460.00	
223001	Бусад хөрөнгө	150,000.00	
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-29,862,210.00	
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөг/

код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	971,471,000.00	929,518,337.77	41,952,662.23	95.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	971,471,000.00	929,518,337.77	41,952,662.23	95.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	949,019,200.00	912,970,187.77	36,049,012.23	96.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	730,548,900.00	708,079,268.00	22,469,632.00	96.92
210101	Үндсэн цалин	524,391,300.00	507,467,242.00	16,924,058.00	96.77
210102	Нэмэгдэл	142,568,900.00	138,593,225.00	3,975,675.00	97.21
210104	Урамшуулал	63,588,700.00	62,018,801.00	1,569,899.00	97.53
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,896,000.00	89,840,768.77	5,055,231.23	94.67
210201	Тэтгэврийн даатгал	67,892,500.00	61,241,165.21	6,651,334.79	90.2
210202	Тэтгэмжийн даатгал	6,750,800.00	7,333,673.81	-582,873.81	108.63
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,400,700.00	5,890,913.16	-490,213.16	109.08
210204	Ажилгүйдлийн даатгал	1,350,200.00	1,408,405.67	-58,205.67	104.31
210205	Эрүүл мэндийн даатгал	13,501,800.00	13,966,610.92	-464,810.92	103.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,355,600.00	48,325,600.00	30,000.00	99.94
210301	Гэрэл, цахилгаан	7,911,500.00	13,096,068.12	-5,184,568.12	165.53
210302	Түлш, халаалт	36,009,100.00	35,229,531.88	779,568.12	97.84
210303	Цэвэр, бохир ус	4,435,000.00		4,435,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	4,666,000.00	4,666,000.00		100
210401	Бичиг хэрэг	350,500.00	350,500.00		100
210402	Тээвэр, шатахуун	2,000,000.00	2,000,000.00		100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	729,600.00	729,600.00		100
210404	Ном, хэвлэл	265,900.00	265,900.00		100
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	272,700.00	272,700.00		100
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,047,300.00	1,047,300.00		100
2105	Нормативт зардал	54,699,200.00	46,205,051.00	8,494,149.00	84.47
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,986,400.00	10,986,400.00		100
210502	Хоол, хүнс	41,233,900.00	32,739,751.00	8,494,149.00	79.4
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,478,900.00	2,478,900.00		100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,300,000.00	5,300,000.00		100
210604	Урсгал засвар	5,300,000.00	5,300,000.00		100
2107	Томилолт, зочны зардал	82,200.00	82,200.00		100
210702	Дотоод албан томилолт	82,200.00	82,200.00		100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,	7,830,600.00	7,830,600.00		100

Төвшрүүлэх сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	үйлчилгээний төлбөр, хураамж				
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,030,600.00	7,030,600.00		100
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	800,000.00		100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,640,700.00	2,640,700.00		100
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,640,700.00	2,640,700.00		100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,451,800.00	16,548,150.00	5,903,650.00	73.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,451,800.00	16,548,150.00	5,903,650.00	73.71
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	20,901,800.00	14,998,150.00	5,903,650.00	71.76
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,550,000.00	1,550,000.00		100
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг				
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг				
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ				
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	971,471,000.00	929,518,337.77	41,952,662.23	95.68
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	917,815,400.00	875,892,737.77	41,922,662.23	95.43
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	917,815,400.00	875,892,737.77	41,922,662.23	95.43
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	53,655,600.00	53,625,600.00	30,000.00	99.94
132001	Орон нутгийн төсвөөс	53,655,600.00	53,625,600.00	30,000.00	99.94
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС				
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР				
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО				
3	Төсвийн байгууллага	1	1		100
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО				
6	Удирдах ажилтан	3	3		100
7	Гүйцэтгэх ажилтан	32	32		100
8	Үйлчлэх ажилтан	27	27		100
11	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	454	454		100
12	Төрийн өмчит ЕБС	454	454		100

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	1,293,883.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	1,293,883.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	1,293,883.64
2104	Хангамж, бараа материалын зардал	-	1,293,883.64
210401	Бичиг хэрэг	-	708,383.64
210402	Тээвэр, шатахуун		
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	585,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	1,293,883.64
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,293,883.64
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,293,883.64
131106	Төсвийн урамшуулал		
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төвшрүүлэх сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, шилэн дансны хууль, 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-ийн аудитор Л.Амарзаяа, аудиторын туслах Ж.Намуун нар гүйцэтгэж, чанарын хяналтыг менежер Ж.Ням-Осор, Захирал Д.Баатарсайхан нар тус тус хэрэгжүүлсэн.

Төвшрүүлэх сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 09 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төвшрүүлэх сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Байгууллагын эрүүл аюулгүй байдал, халдвар хамгааллын дэглэмд нийцүүлэн хичээл, сургалтын үйл ажиллагааг тасралтгүй явуулах, багш бүр ээлжит хичээлийн бэлтгэлийг чанартай ханган, 5 настай хүүхдэд СӨБ-ын агуулгыг бүрэн эзэмшүүлж, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлж ажиллах”-д оршино гэж тодорхойлсон байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургууль хүний хөгжлийн төв байх
- Ажлын хариуцлага ёс зүйг дээшлүүлж хууль дүрмийг хэрэгжүүлэх
- Сургалтын чанар үр дүнг дээшлүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороосон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор батлагдсан “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналт шалгалтын жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хичээл сургалт, хичээлээс гадуурх үйл ажиллагаа, хөдөлмөрийн сахилга бат, хууль тогтоомжийн хэрэгжилт, санхүү аж ахуйн үйл ажиллагааны өнөөгийн байдалд хяналт шалгалт хийж ажилласан байна. Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төвшрүүлэх сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 971.5 сая төгрөгөөс 1 хувиар буюу 9.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 7.3 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төвшрүүлэх сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 83.6 сая төгрөгөөр буюу 2,4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн дансанд гарсан өөрчлөлт байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	2.1		-2.1
Бараа материал	86.3	98.8	12.5
Үндсэн хөрөнгө	3,394.3	3,300.3	-94.0
Нийт хөрөнгө	3,482.7	3,399.1	-83.6
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,482.7	3,399.1	-83.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,482.7	3,399.1	-83.6

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлагын дансны үлдэгдэл 2.1 сая төгрөгөөр буурсан нь тэтгэвэрт гарсан, буцаж ажиллаж байгаа ажиллагсдын цалингаас НДШ-ийг энгийн ажилчнаар тооцон авч нийгмийн даатгалд тайлагнахдаа тэтгэвэрт гарсан ажилтнаар тайлагнасны зөрүүг төлж барагдуулсан байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 98.8 сая төгрөг болж 12.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 110.9 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан 3.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, 102.1 сая төгрөгөөр хасагдаж, 0.1 сая төгрөгийн материал актлагдсантай холбоотой байна
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,300.3 сая төгрөг болж 9.4 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд үнэ төлбөргүй хүлээн авсан 0.4 сая, үндсэн хөрөнгө/хуримтлагдсан элэгдэл 0.3 сая/ төгрөгийн хамт, дахин үнэлж нэмсэнтэй холбоотой 32.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, 10.4 сая төгрөгийн хөрөнгө акталсан, үндсэн хөрөнгийн дахин үнэлэхтэй холбоотойгоор данснаас 54.8 сая төгрөгийн хөрөнгө хассан байна.

Хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдэл 508.9 сая төгрөг байснаас тайлант хугацааны элэгдэл 127.0 сая төгрөгөөр нэмэгдсэн, үндсэн хөрөнгийн дахин үнэлэхтэй холбоотойгоор данснаас хассан элэгдэл 65.2 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө 0.3 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй шилжин ирснээр тус тус хасагдаж 570.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн 83.6 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд алдагдалтай ажилласантай холбоотой байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

	/сая төгрөг/		
Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	901.7	917.8	16.1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	76.5	53.7	-22.8
Үндсэн үйл ажиллагааны орлого	105.0		-105.0
Нэмэлт санхүүжилтийн орлого	0.4	1.3	0.9
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0.0	36.7	36.7
Үйл ажиллагааны орлого	1,083.6	1,009.5	-74.1
Цалин, шимтгэлийн зардал	796.1	800.0	3.9
Бараа үйлчилгээний зардал	113.8	99.1	-14.7
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2.1	6.3	4.2
Бараа үйлчилгээний бусад зардал	115.5	129.2	13.7
Урсгал шилжүүлэг	13.2	58.5	45.3
Хөрөнгө шилжүүлсэн			0.0
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз			0.0
Үйл ажиллагааны зардал	1,040.7	1,093.1	52.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	42.9	-83.6	-126.5

Тус сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 74.1 сая төгрөг буюу 6.8 хувиар буурсан нь санхүүжилт багассантай холбоотой байна. Төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулж ажилласан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 971.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 971.5 сая төгрөгөөр хянаж баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 971.5 сая төгрөгийн төсөв баталснаас гүйцэтгэлээр тусгай зориулалтын сангаас 875.9 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 53.6 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 887.6 сая төгрөгийг зарцуулж 41.9 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 887.6 сая төгрөг буюу 95.5 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 1,293.9 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг авч бичиг хэргийн материалд 708.4 сая, хог хаягдал зайлуулахад 0.6 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Архангай аймгийн Засаг даргын тамгын газраас 0.4 сая төгрөгийн анхны өртөгтэй 0.3 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй төмөр хайс хандиваар ирсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

Тус байгууллага нь 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 11 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 88.0 хувь байна.

Тайлант онд хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 5 арга хэмжээнд зориулан нийт 929.5 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 887.6 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд төсвийн гүйцэтгэл 99.85 хувь байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд батлагдсан төсвийн хүрээнд зардлыг зарцуулсан байна. Үүнд:

1. Үйлчилгээний ажилтан, галч нарт нормын хувцас авсан байна.
2. Албан томилот, бичиг хэрэг, тогтмол зардлуудыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус сургууль нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 156 мэдээллээс 134 мэдээллийг хугацаанд нь, 12 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтыг хэрэгжүүлж, мэдээллийг хуульд заасан хугацаанд тогтмол мэдээлж хэвших гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй тул албан шаардлага хүргүүлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд дараах зөрчлүүд илрэв. Үүнд:

Тайлант хугацаанд тус сургууль үйлчилгээний ажилтан, галч нарт 2.5 сая төгрөгийн нормын хувцас худалдан авсан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.4 "заасан энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт нь нь холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 26.7 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн ба 66.6 хувь хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарч үзэх асуудалгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 109.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснийг санхүүгийн тайланд залруулсан.

Залруулагдаагүй алдаа, зөрчил байхгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Цалингийн зардал данснаас НДШ, ХАОАТ, байгууллагад өгөх өглөгт нийт 69.2 сая төгрөгөөр алдаатай бүртгэсэн.
- Үлдэх өртөггүй 32.9 сая төгрөгийн хөрөнгийг ашиглалтын хугацааг сунгаж орлого авахдаа анхны өртгөөр авсан
- Үлдэх өртөгтэй 7.1 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хасаж орлого авахдаа өмнөх үеийн хуримтлагдсан ашгийг бууруулсан алдааг тус тус залруулав.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

-----oOo-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Төвшрүүлэх сумын Ерөнхий боловсролын сургууль	3	109.2	3	109.2						
Дүн		3	109.2	3	109.2	0	0	0	0	0	0
Санхүүгийн тайлангийн аудитын шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Төвшрүүлэх сумын Ерөнхий боловсролын сургууль	2	2.5			0	0	2	2.5	0	0
Дүн		2	2.5	0	0	0	0	2	2.5	0	0
Нийт дүн		5	111.7	3	109.2	0	0	2	2.5	0	0